



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/215

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “д”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны ээлжит 5 дугаар хуралдааны 07 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 28 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдах Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлыг Барилгын хөгжлийн төвөөс нэгдсэн байдлаар зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажиллаж байгаа тул зураг төсвийн зардал 100,0 /нэг зуун/ сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн аймгийн хэмжээнд шинээр баригдах дэд бүтэц, барилга байгууламжийн зураг, төсвийн зардлаас санхүүжүүлсүгэй.

2. Зураг, төсөв боловсруулах арга хэмжээний зардал болох 100,0 /нэг зуун/ сая төгрөгийг дээрх зардлаас зарцуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-Очир, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д даалгасугай.


ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

4. Улсын аварга шалгаруулах спорт аэробикийн тэмцээнийг бэлтгэл зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж тайлагнахыг Комиссын дарга /Ж.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР